

Нэгдүгээр хэсэг. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавар, нийт 76 оноотой. Даалгавар бүр 5 сонгох хариулттай бөгөөд зөвхөн 1 хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. Хариултын хуудасны заавартай уншиж танилцаарай. Амжилт хүсье.

1. Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Нарийн голын хөндийн оршин суугчдын эрхэлж байсан аж ахуй аль нь вэ? (1 оноо)

A. Ан агнуурын аж ахуй B. Олзворлох, түүвэрлэх аж ахуй C. Мал аж ахуй
D. Тариалангийн аж ахуй E. Үйлдвэрлэх аж ахуй

2. Эртний хүмүүс хатуу цахиурлаг чулуугаар хийсэн хусуур, хянгар зэвсгийг ямар зориулалтаар ашиглаж байсныг зөв тодорхойлно уу. (2 оноо)

1. Амьтны арьс хуулах 2. Том амьтдыг агнах 3. Мод зорох
4. Жад хийх 5. Ялтсан зэвсэг хийх

A. 2,5 B. 1,4 C. 2,4 D. 3,5 E. 1,3

3. Гадаргууг нь мөлийлгөн өнгөлсөн нарийн хийцтэй чулуун сүх бий болсон нь аль үед холбогдох вэ? (1 оноо)

A. Неолит B. Мезолит C. Дээд палеолит D. Энеолит E. Доод палеолит

4. Цэгийн оронд тохирох утгыг олно уу. (1 оноо)

Хүрлийн үе, түрүү төмрийн үед нүүдэлчдийн нийгэм соёл, аж ахуйн цогц тогтолцоо бүрэлдэж, бий болов.

A. Суурин иргэншил B. Худалдаа C. Нүүдлийн иргэншил
D. Амьтны загварт урлаг E. Овог, аймаг

5. Нүүдэлчдийн байгуулсан анхны төрт улс аль нь вэ? (1 оноо)

A. Хятан B. Хүннү C. Жужан D. Түрэг E. Сяньби

6. Дараах өгөгдлөөс зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу. (2 оноо)

a. Модунь шаньюй b. Гиюй шаньюй	1.	Хүннү улсын хүчирхэгжилт оргил үедээ хүрэв.
	2.	НТӨ 174-161 он, өргөмжилсөн нэр нь Лаошан
	3.	Дорнод Туркестаны үлэмж хэсгийг өөртөө нэгтгэв.
	4.	Хань улсаас их хэмжээний алба авах болов.

A. a-1,3, b-2,4 B. a-2,3, b-1,4
C. a-1,4, b-2,3 D. a-2,3, b-3,4 E. a-3,4, b-1,2

7. Шар мөрөн, Ляоси орчмоор нутаглаж байсан Сяньбийн нэг салбарыг хэрхэн нэрлэх болсон бэ? (1 оноо)

A. Хятан B. Хүннү C. Жужан D. Түрэг E. Уйгур

8. Хятан аймгууд ба Түрэг улсын харилцааг зөв тодорхойлсон нь аль вэ? (2 оноо)

A. Хятан аймгууд Түрэгтэй “Энх ургийн гэрээ” байгуулж, хилээ Цагаан хэрмээр тогтоов.
B. Хятан аймгууд Түрэгийн түрэмгийллийн эсрэг тэмцэж, бие даан оршиж байв.
C. Түрэг улс, Хятан аймгууд руу 3 жил тутам их цэргээр довтолж, түйвээдэг байв.
D. Хятан аймгууд Түрэгийг түрэмгийлэн захиргаандаа оруулав.
E. Түрэг улс, Хятан аймгуудад алба барьж байв.

9. Эсгий урлалын арга технологи өндөр хөгжсөнийг харуулах дурсгал Ноён уулын язгууртны булшнаас олдсон нь аль улсын үед холбогдох вэ? (1 оноо)

A. Хүннү B. Сяньби C. Жужан D. Түрэг E. Уйгур




10. Хүннүчүүдийн шашин шүтлэгийг зөв илэрхийлсэн хариултыг сонгоно уу. (1 оноо)
 А. Ману бурхан шүтдэг байв. В. Манихейн шашинтай байв.
 С. Шива бурхан шүтдэг байв. D. Хиндү шашинтай байв.
 E. Бөө мөргөлтөн байв.
11. Дараах сурвалжийн мэдээ нь ямар улсын тухай өгүүлж байна вэ? (1 оноо)
 “6390 оны зун. Олег ван их цэргээ авч, аян дайнд мордов... Смоленск хотыг эзлэн авч, өөрийн хүнээр захируулав...”
 А. Вандаул улс В. Орос улс С. Франк улс D. Зүүн Гот улс E. Византын эзэнт улс
12. Майя, Ацтек, Инкийн түүхэнд холбогдох зөв бодомжийг олно уу. (2 оноо)
 А. Майячууд Андын нуруугаар нутаглаж байв.
 В. Ацтекүүд 60 метр өндөр “Нарны сүм”-ийг байгуулав.
 С. 1570 онд португалчууд Ацтекийг эзлэн авав.
 D. Ацтекүүд Теночтитлан хотыг байгуулав.
 E. Чичен Ица бол Ацтекийн нийслэл байв.
13. Исламын шашныг үндэслэгч Мухаммедын төрсөн хот аль вэ? (1 оноо)
 А. Антиох В. Ясриб С. Мекка D. Иерусалим E. Медина
14. Тан, Сүн улсуудын түүхэнд холбогдох **А ба Б** жагсаалтад тохирох хариултыг сонгоно уу. (2 оноо)
А. Перс, Солонгос, Аннам **Б. Ли Юань, Жао Куанжин**
 А. Газар нутаг, цэргийн жанжид В. Хил хязгаар, улсыг үндэслэгчид
 С. Хил хязгаар, босогчид D. Нийслэл хот, түшмэд
 E. Гол мөрөн, хаад
15. Ираны эзлэн түрэмгийлэгчид 1206 онд Энэтхэгт Дели төвтэй султант улс байгуулжээ. Тус улсын ноёлох хэсэг ямар шашин шүтэж байсан бэ? (1 оноо)
 А. Лалын шашин В. Загалмайтны шашин С. Шинтогийн шашин
 D. Бурхны шашин E. Индус шашин
16. Тохирох утгатай нь зөв харгалзуулсныг дугуйлна уу. (1 оноо)
 1. Бусидо а. Их Будда
 2. Катакана б. Гадаад үгийг тэмдэглэхэд хэрэглэдэг.
 3. Дайбуцу в. Дайчны замнал
 А. 1a,2c,3b В. 1a,2b,3c С. 1b,2a,3c D. 1c,2a,3b E. 1c,2b,3a
17. XII зууны үеийн Монгол улсын гол аймагт аль нь багтаж байсан бэ? (1 оноо)
 А. Онгуд В. Тайчуд С. Хэрэйд D. Татар E. Мэргид
18. Монгол-Татарын зөрчлийн шалтгааныг зөв тодорхойлсон хариултыг олно уу. (2 оноо)
 А. Амбагай хан нас барж, Хадаан тайш хан болсноос
 В. Байгаль нуур, Баргужин төхмийн нутгийг булаалдан тэмцэлдсэнээс
 С. Инанч билгэ хаан таалал төгссөний дараа төрийн эрх мэдлийн төлөө тэмцэлдсэнээс
 D. Хөлөн, Буйр нуур орчмын мал өсгөхөд тохиромжтой бэлчээр нутгийн төлөөх тэмцэл
 E. Маркус хан нас барж, Сарык хан захирах болсноос
19. Адилтгах замаар зөв хариултыг дугуйлна уу. (1 оноо)
Найман-Таян хан **Жадаран-?**
 А. Тоорил хан В. Жамуха С. Тогтога D. Хутуга бэхи E. Мэгүжин сүүлт



20. Чингис хаан 1204 онд Наймантай хийсэн тулааны төлөвлөгөөг боловсруулахдаа дайсандаа сэтгэл зүйн цохилт өгөхийн тулд ямар арга боловсруулсан бэ? (1 оноо)
 А. Цэргийн гол хүчээ ухраасан
 В. Зориуд туранхай агт олзлуулсан
 С. Тулааны өмнө цэрэг бүр олон гал түлсэн
 D. Цэргийн хүчээ олон хэсэгт хуваасан
 E. Тулааны өмнө задын арга хэрэглэсэн
21. 1260 онд Кайпин буюу хожмын Шандуд хаан ширээнд хэн суусан бэ? (1 оноо)
 А. Хубилай
 В. Гүюг
 С. Аригбөх
 D. Мөнх
 E. Өгөдэй
22. Их Юань улс нийт хүн амаа дөрвөн зэрэглэлд хуваажээ. Хоёрдугаарт ямар хүн ордог вэ? (1 оноо)
 А. Нанхиад хүмүүс
 В. Монгол хүн
 С. Ази, Европ, Африк
 D. Умард хятадын зүрчид, хятан
 E. Өнгөт нүдтэн хэмээх уйгур, перс, араб
23. Газрын зургийг ажиглаад зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)

Алтан ордны улсын нийслэл Сарай хотын байршлыг хэдийн тоогоор тэмдэглэсэн байна вэ?



А. 3

В. 1

С. 4

D. 5

E. 2

24. Тогоонтөмөр хааныг хэн залгамжилсан бэ? (1 оноо)
 А. Аюушридар
 В. Төгстөмөр
 С. Майдарбал
 D. Ринчинбал
 E. Хайсан
25. Монголын улсын цэргийн зүүн жигүүрийн жанжин Нагачу 1387 онд Мин улсад дагаж оров. Энэ нь хэддүгээр зууны, хэддүгээр хагаст болсон үйл явдал вэ? (1 оноо)
 А. XIV зууны I хагас
 В. XIII зууны II хагас
 C. XIII зууны I хагас
 D. XIV зууны II хагас
 E. XV зууны I хагас
26. XIV-XVII зууны үеийн Өвөр Монголд хамаарах өгөгдлүүдээс зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)

1. Ашихай
 4. Арын 7 отог

2. Асуд аймаг
 5. Хатан голын сав газар

3. Хэрлэн голын сав газар
 6. Алчүболд

А. 1,2,3

В. 2,5,6

С. 1,4,5

D. 3,4,6

E. 1,3,4

27. XVII зууны үед Төвөдөд бурхны шашны урсгалууд, номлол сургаалаа дэлгэрүүлэхийн төлөө өрсөлдөж байв. Ямар урсгалуудын хооронд гол өрсөлдөөн өрнөж байсан бэ? (1 оноо)
 А. Хинаяна, Махаяна
 В. Суннит, Шийт
 C. Күнз, Дао
 D. Хар, Цагаан
 E. Улаан, Шарын



28. Дараах сурвалжийн мэдээнд хийсэн оновчтой дүгнэлтийг сонгоно уу. (2 оноо)
- “Манжийн үнэн магад хууль”-аас: *Монголын Лигдэн хаан Алтан улсын Нурхач хаанд захидал илгээхэд Нурхач дараах хариуг илгээв. “...Би сонсвоос эрт Дайду хот юугаан Хятадын Дай Мин улсын Хун У хаанд автахуй цагт дөчин түмэн Монголоо автаж, зургаан түмэн улс дутааж гарвай хэмээн сонслоо. Тэр зургаан түмэн монгол бүгд эдүгээ чамд буюу?...”*
- A. Алтан улсын Нурхач хаан, Мин улсын хаанд Монголыг хамтран эзлэх тухай өгүүлсэн
 B. Лигдэн хаан бүх Монголыг нэгтгэн захирч байсан тухай өгүүлсэн
 C. Зургаан түмэн Монгол Мин улсын Хун У хаантай байлдсан тухай өгүүлсэн
 D. Лигдэн хаанд монголчууд бүгд захирагддаггүй тухай өгүүлсэн
 E. Баруун зүүн Монголын тухай өгүүлсэн
29. Монголчуудын мод, зэс, хорголж, төмөр зэргийг ашиглан номыг олон тоогоор хэвлэх аргыг юу гэдэг вэ? (1 оноо)
- A. Дүрслэх
 B. Хуулан бичих
 C. Барлах
 D. Үйсэн дээрх бичих
 E. Орчуулан бичих
30. Хот айлаар нүүдэллэхээс өмнөх монголчуудын нүүдлийн зохион байгуулалт аль нь вэ? (1 оноо)
- A. Аймгаар
 B. Хороогоор
 C. Хүрээгээр
 D. Отгоор
 E. Хошуугаар
31. 1804 онд анхны төмөр замын зүтгүүрийг хэн зохион бүтээсэн бэ? (1 оноо)
- A. Орвил Райт
 B. Жорж Стефенсон
 C. Сирьюс Хол МакКормик
 D. Ричард Трэвитик
 E. Вилбур Райт
32. Улс төр, эдийн засгийн хувьд хэлбэрийн төдий тусгаар тогтносон боловч эдийн засгийн эрх мэдэлгүй болсон орныг юу гэж нэрлэдэг вэ? (1 оноо)
- A. Колони орон
 B. Хагас колони орон
 C. Хараат орон
 D. Эзлэгдсэн орон
 E. Буурай хөгжилтэй орон
33. **А ба Б** жагсаалтыг ямар шалгуураар гаргасан бэ? (2 оноо)
- A. Египет, Судан**
 A. Герман, Италийн колониуд
 C. Итали, Бельгийн колониуд
 E. Англи, Францын колониуд
- B. Камбож, Баруун ба экваторын Африк**
 B. Герман, Францын колониуд
 D. Нидерланд, Францын колониуд
34. Их Британичуудыг очихоос өмнө Австрали тивийн уугуул иргэд-Аборигенчүүд ямар аж ахуй эрхэлдэг байсныг зөв тодорхойлно уу. (2 оноо)
- A. Ан агнуур, загас барих, олзворлох, түүвэрлэх
 B. Загас барих, олзворлох, үйлдвэрлэх, газар тариалан
 C. Загас барих, түүвэрлэх, худалдаа, мал аж ахуй
 D. Үйлдвэрлэх, газар тариалан, ан агнуур, загас барих
 E. Мал аж ахуй, олзворлох, түүвэрлэх, үйлдвэрлэх
35. Газар доор урт хонгил ухаж, төмөр зам тавьснаар олон хүнтэй хотууд түргэн хямд тээврийн хэрэгсэлтэй болов. Анхны метро ямар хотод баригдсан бэ? (1 оноо)
- A. Парис
 B. Лондон
 C. Москва
 D. Берлин
 E. Милан



36. XIX зууны үед Францын Ж.П.Рамеу, Оросын П.И.Чайковский нарын “Хунт нуур”, “Нойрсож буй гоо бүсгүй”, “Щелкунчик” зэрэг бүтээлүүдийн ач холбогдлыг олно уу. (2 оноо)

- A. Кино урлаг хөгжих эхлэл тавигдсан
- B. Уран барилга хөгжихөд түлхэц болсон
- C. Балетын урлаг хөгжихөд чухал нөлөө үзүүлсэн
- D. Уран зохиол өндөр хөгжих эхлэл болсон
- E. Уран бүтээлчид романтизмын чиглэлээр бүтээл туурвих болсон

37. Өвөр Монголын ноёд Мүгдэнд, Манжийн хааныг эзэн хаанаа хэмээн зөвшөөрчээ. Энэ үйл явдлаас 119 жилийн дараа Манжийн эрхшээлд орсон улсыг дугуйлна уу. (1 оноо)

- A. Халимаг
- B. Халх Монгол
- C. Хөх нуурын Монгол
- D. Буриад Монгол
- E. Зүүнгар улс

38. 1651 онд Байгаль нуурын баруун талд оросуудын байгуулсан шивээг дугуйлна уу. (1 оноо)

- A. Түнхэн
- B. Эрхүү
- C. Нэрчү
- D. Балганск
- E. Братск

39. 1691 онд дотоод задралын улмаас тусгаар байдлаа алдсан нь аль вэ? (1 оноо)

- A. Хошууд Монгол
- B. Өвөр Монгол
- C. Зүүнгар
- D. Халх Монгол
- E. Буриад Монгол

40. Дараах үйл явдлуудаас Халх Монгол Манжид эзлэгдсэн гадаад шалтгааныг олно уу. (1 оноо)

- A. Халхын баруун, зүүн гарын ноёд зөрчилдөв.
- B. Оросууд Буриадаас алба гувчуур авах, эзлэн захирахыг эрмэлзэв.
- C. Галдан бошигт хаан Халхад довтлов.
- D. Түшээт хан Халхын баруун гар руу довтлов.
- E. Лигдэн хаан нас барав.

41. Амарсанаагийн бослогод холбогдох үйл явдлыг сонгоно уу. (1 оноо)

Зүүнгарын Амарсанаагийн бослого	1	Орос улс руу зугтаж гарсан
	2	Газар, түрээслэх худалдаалахыг эсэргүүцсэн
	3	Өртөө, харуул, цэргийн албыг хаяж явсан
	4	3000 цэргээ удирдан Манжтай байлдсан

- A. 1,4
- B. 2,4
- C. 3,4
- D. 1,3
- E. 2,3

42. Жирмийн чуулганы Жалайд хошууны тайж Цогдалай Манжийн эсрэг зэвсэгт бослого гаргасан шалтгааныг зөв тодорхойлно уу. (2 оноо)

- A. Ихэтуаны бослогыг Монгол цэргээр дарахыг эсэргүүцсэн
- B. Зүүнгарын монголчуудыг олон арван мянгаар нь хядсанд
- C. Хятад тариачдад газар түрээслэх, худалдах, харийн шашин дэлгэрүүлэхийг эсэргүүцсэн
- D. Халх Монголд Хятадын мөнгө хүүлэгч, худалдаачдын мөлжлөг хэрээс хэтэрсэн тул
- E. Монголчуудаас авах манжийн алба татвар нэмэгдсэн учир

43. 1911 онд үндэсний хувьсгал ялсны дараа оны цолыг хэрхэн нэрлэсэн бэ? (1 оноо)

- A. Бүгд найрамдах
- B. Олноо өргөгдсөн
- C. Монгол улсын
- D. Тусгаар тогтносон
- E. Мандан бадарсан




44. Түүхэн үйл явдлыг он цагийн хувьд зөв дараалалд оруулсан хариултыг сонгоно уу. (2 оноо)

1. “Шинэ толь” сонин хэвлэгдэв.
2. “Монгол-Оросын худалдааны гэрээ”-г байгуулав.
3. “Улсын хөрөнгийг захирах газар”-ыг байгуулав.

A. 1,3,2 B. 3,1,2 C. 1,2,3 D. 2,3,1 E. 2,1,3

45. Он тооллын шугамыг ажиглан тохирох хариултыг сонгоно уу. (1 оноо)



- A. Ардын Засгийн Газар байгуулагдав. B. Д.Сүхбаатарыг цэргийн жанжнаар томилов.
 C. Хиагт хотыг чөлөөлөв. D. Нийслэл Хүрээнд нууц бүлгэм байгуулагдав.
 E. Нийслэл хүрээг чөлөөлөх шийдвэр гаргав.

46. Хүснэгтийг ажиглан “Улсын түр цагийн хурлын дүрэм”-д хамаарах зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)

1. Он цаг	2. Үүрэг	3. Үр дүн
a. 1922 оны 1 сард	a. Улсын хэмжээнд бодлого, шийдвэр боловсруулах	a. Үндсэн хуулийн үүргийг гүйцэтгэж байсан.
b. 1921 оны 8 сард	b. Эзэн, хамжлагын харилцааг зохицуулах	b. УИХ хуралдах хүртэл Засгийн газарт зөвлөх
c. 1922 оны 5 сард	c. Богд хаан ба Ардын засгийн газрын хоорондын харилцааг зохицуулах	c. Нийгэм, эдийн засгийн хүрээнд ардчилсан өөрчлөлт гарсан.

A. 1b,2c,3a B. 1b,2a,3b C. 1c,2a,3b D. 1c,2b,3b E. 1a,2a,3b

47. Улсын анхдугаар Их Хурлаар шийдвэрлэсэн хамгийн гол асуудал юу вэ? (1 оноо)

- A. Бүх нийтийн сонгуулийн эрхийг баталсан
- B. Хамжлагат ёсыг халах шийдвэр гаргасан
- C. Үндсэн хуулийг батлан тогтоосон
- D. Нийслэлийн нэрийг өөрчилсөн
- E. Үндсэн хууль боловсруулах комисс байгуулсан

48. Зүүнтний алдаатай бодлогоор 1932 онд 16 сая болсон мал сүргийн тоо Шинэ эргэлтийн бодлогын үр дүнд 1940 он гэхэд хэд болсон бэ? (1 оноо)

- A. 32 сая 204 мянга B. 28 сая 204 мянга
 C. 30 сая 204 мянга D. 26 сая 204 мянга E. 24 сая 204 мянга



49. 1932 оны 5 сард ЗХУ-д хуралдсан Бүх Холбоотны Коммунист намын Төв хорооны Монголын талаар тусгай тогтоол гарав. Уг тогтоолд хамаарах агуулгыг зөв ялгасан хариултыг сонгоно уу. (2 оноо)

1. Үндсэн хуулиар олгогдсон хүний эрхийг бүдүүлгээр зөрчсөн
2. Ардын аж ахуйтны мал сүргээс хураах албан татварыг хөнгөвчилсөн
3. Монголд ЗХУ-ын социализм байгуулах үйл ажиллагааг шууд хуулбарласан
4. Чинээлэг аж ахуйтанд зээл олгодоггүй байсан журмыг халсан
5. Ардын сүсэг бишрэлийг доромжилсон

A. 2,3,4

B. 1,3,5

C. 2,3,5

D. 3,4,5

E. 1,2,4

50. Чөлөөлөх дайны үеэр Л.Аюуш, Д.Данзанваанчиг нар хаана болсон тулалдаанаар БНМАУ-ын баатар болсон бэ? (1 оноо)

A. Чуулалт хаалганд

B. Мүгдэнд

C. Халх голд

D. Номун ханд

E. Жанчхүүгийн давааны бэхлэлтэд

51. Монголын ардчилсан нам эмхлэн байгуулагдсаныг хэдэн онд зарласан бэ? (1 оноо)

A. 1991

B. 1990

C. 1992

D. 1989

E. 1993

52. Улс төрийн товчоог хэзээ, ямар үйл явдлаар огцруулсан бэ? (2 оноо)

A. 1990 оны 3 сарын 7-ны өдөр, Сүхбаатарын талбайд зарласан өлсгөлөнгөөр

B. 1990 оны 3 сарын 22-24-ны өдөр, АИХ-ын чуулганаар

C. 1990 оны 2 сарын 18-ны өдөр, МоАХ-ны анхдугаар их хурлаар

D. 1990 оны 3 сарын 12-14-ны өдөр, МАХН-ын бүгд хурлаар

E. 1990 оны 4 сарын 27-ны өдөр, Ялалтын талбайд болсон цуглаанаар

53. Тохирох утгатай нь зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу. (2 оноо)

1.	Улсын бага хурлын дарга	a.	П.Очирбат
2.	Ерөнхий сайд	b.	Р.Гончигдорж
3.	Ерөнхийлөгч	c.	Д.Бямбасүрэн

A. 1c,2a,3b

B. 1b,2c,3a

C. 1c,2b,3a

D. 1b,2a,3c

E. 1a,2c,3b

54. Монголын төр улс төрийн хилс хэргээр хэлмэгдэгсдийн ар гэрээс уучлалт гуйж, цагаатгах ажлыг хэдэн оноос өрнүүлсэн бэ? (1 оноо)

A. 1996 он

B. 1992 он

C. 2003 он

D. 2007 он

E. 2010 он

55. Дараах өгөгдлөөс 1990 оны хувьсгалын үр дүнд оюун санааны хүрээнд гарсан өөрчлөлт аль нь вэ? (2 оноо)

A. Анхны чөлөөт ардчилсан сонгууль явагдаж, Монгол улс ерөнхийлөгчтэй болов.

B. Монгол Улс олон намын тогтолцоонд шилжиж, парламентын засаглалтай болов.

C. Чингис хааны мэндэлсэн өдрийг "Монгол бахархлын өдөр" болгон тэмдэглэх болсон

D. Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт эдийн засагт шилжсэн

E. Монгол Улс шинэ Үндсэн хуулиа баталж, өнөөгийн ардчилсан тогтолцоо бий болов.

56. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын анхдагч нөхцөлийг зөв тодорхойлсныг сонгоно уу. (2 оноо)

A. Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, ёс заншлаа хадгалж хамгаалах, хөгжүүлэх

B. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нэгдмэл байдлыг хамгаалан бататгах

C. Монгол хүний эрүүл аюулгүй амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх

D. Хүнсний аюулгүй байдлыг хангах

E. Байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах



Хоёрдугаар хэсэг

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай, тус бүр 6 оноотой. Нийт 24 оноо. Даалгавруудын хариултыг бөглөхдөө хариултын хуудасны 2-р хэсгийг бөглөх заавартай сайтар танилцаарай.

2.1 Их Монгол улсын төр, засаг захиргааны бүтэц ба албан тушаалтнуудыг зөв харгалзуулна уу. (6 оноо)

a. Чингис хааны дөрвөн нохос	1. Мухали
b. Их заргач	2. Чулуун
c. Зүүн түмний захирагч	3. Үсүн өвгөн
d. Төрийн бэхи	4. Шихихутуг
e. Чингис хааны дөрвөн хүлэг	5. Зэв
f. Баруун түмний захирагч	6. Боорчу

2.2 Эрдэмтдийг шинжлэх ухааны ололт нээлтүүдтэй нь зөв тохируулна уу. (6 оноо)

a. Фаулер	1. Өвдөлт намдаах үйлчилгээтэй химийн бодисуудыг өвчин намдаагч, бүх мэдрэхүйг үгүй болгодог бодисыг мэдээ алдуулагч гэж нэрлэв.
b. Вэндэлл Холмс	2. Уурын анжсыг зохион бүтээж газар тариаланд хэрэглэх болов.
c. Семюэл Морзе	3. Динамитыг зохион бүтээж, барилга, цэргийн салбарт ашиглав.
d. Альфред Нобель	4. Холбооны шинэ телеграф бүтээж, цахилгаан соронзон аппаратын тусламжтайгаар мэдээллийг цэг зураасаар дамжуулдаг бүтээл хийв.
e. Александр Грэхэм Бэлл	5. 1000 гаруй бүтээл зохион бүтээж, 1093 патент эзэмшдэг байв.
f. Томас Эдисон	6. Анхны телефон утсыг зохион бүтээв.

2.3 БНМАУ-ын нийгэм, эдийн засагт гарсан өөрчлөлтийг холбогдох ойлголттой нь зөв тохируулна уу. (6 оноо)

a. Х.Чойбалсан	1. Үзэл суртлын хатуу шалгуур бий болсон
b. Авторитар дэглэм	2. Хөдөө аж ахуйг шинээр зохион байгуулсан
c. Пролетарийн интернационалч зарчим	3. Нэг үзэл суртлыг тунхаглаж, хувийн өмчийг үгүйсгэн нийтийн өмчийг тулгах болсон
d. Нэгдэлжих хөдөлгөөн	4. Төр нийгмийг удирдан чиглүүлэх цорын ганц хүч бол МАХН мөн.
e. Атрын I аян	5. Хууль ёсыг ноцтой зөрчиж үй олон хүнийг хэлмэгдүүлсэн
f. Хүнд суртлын тогтолцоо	6. Ургацын хэмжээнд бус талбайн хэмжээнд анхаарсан

2.4 БНМАУ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын хөгжилд гарсан өөрчлөлтийг холбогдох ойлголттой нь зөв харгалзуулна уу. (6 оноо)

a. 1962 он	1. Сургуулийн бүтцийг 3+5+2 болгов.
b. 1968 он	2. Мандухай сэцэн хатан кино дэлгэцнээ гарав.
c. 1972 он	3. Олон улсын Олимпын хороонд элсэв.
d. 1982 он	4. Дээд сургуульд 6900 оюутан суралцаж байв.
e. 1960 он	5. БНМАУ-ын "Боловсролын тухай хууль" батлав.
f. 1988 он	6. Мехикогийн Олимпоос Ж.Мөнхбат мөнгөн медаль авав.

